

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэдэндорж	Дугаар	Л197
Оршин суугаа аймаг	Завхан	Оршин суугаа сум	Түдэвтэй сум
Төрсөн газар	Нөмрөг	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хатавчийн хүрээ Цогтой вангийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ЗАТТ 036
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 20	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Завхан аймгийн Нөмрөг сумын Хатавчийн хүрээ Цогтой вангийн хүрээ

Цэдэндорж: Би 1921 онд төрсөн. Монгол тооны 6 настай байхдаа Рашаан гүний хошууны Хатавчийн хүрээ гэдэг хоёр дахь хүрээн дээр нь эхэлж сууж Төвд ном үзсэн. Цогчины бол чойрын гурван уншлага дуусгаж ёнзог шүүлгэсэн. Чойрт ороод хадаг шидавын нэг хоёр жил чойрын онол үзсэн. Ингээд хүрээ тарсан. Манай тэр хүрээ бол Засагт хаан аймгийн Рашаан гүний хошууны хоёр дахь хүрээ нь. Энэ хүрээн дээр бол гурван зуу гаран, дөрвөн зуу гаруй лам сууж байсан юм билээ. Энэ хүрээн дээр ойролцоо газруудаас, энэ хилээс манай одоогоор бол энэ Баянтэс сумын тэр цаад харуулын байсан жижиг хүрээнүүдийн лам нар ирж сууж байсан. Энэ Увсаас лам нар ирж сууж байсан. Гадны лам нарууд энэ дээр ирж бас суудаг. Өөрийн дотоодын лам нар олонтой, бас нэлээн нэр алдартай ийм хүрээ. За гол ирэхдээ бол энд шашны чойрын талаар их сайн гэж , чойр үзэх гэж ирж байсан. Тэр нь ч ортой байх. Халхын хэмжээгээр гайхагдаж байсан чойрын онолын 3 том лам байгаа. Тэр нь тэр Баянхонгор аймгийн...За одоо нэр нь орж ирэхээ байчихлаа. Энэ Рашаан Ангиюмдаанготов гэж Улаанбаатарт алдаршсан их олон шавь нартай хоёр тийм том лам байсан. Тэгэхлээр тэр чойр сайтай байсан. Энд бол тэр Дамба хамба энэ тэр гээд их олон сайн сайн гэвш нар гэж яригдаж байсан ийм улсууд байсан. Ийм л хүрээн дээр ном үзэж байсан. Тэгээд 1937 онд эхэлж лам нар баригдаад, тэр өвөл хүрээ тарсан. Тэгээд л яахав, хүрээ тараад л хүрээ утсан. Хүрээ утсаны дараачийн нэг жил бол тэр хүрээн дээр байсан хорин гурван дуганыг бүгдийг нь буулгасан. Тэрнээс тэр цогчин дуган нь бол гурван давхар, хошууны хүчээр гурван жил барьсан ийм дуган байсан. Их гоёмсог, тэрнийг бол аймгийн төвөөс ирсэн тэр барилга буулгадаг их мэргэжлийн болсон , энэ тэндхийн их олон хүрээ буулгасан юм байх. Хоёр хүн ирээд гурван өдөр буулгасан. Тийм их сонин түүх байдаг юм. Тэр үед нь бол тэр хүрээ буулгаж байхад нь Нөмрөгийн захиргааны дарга байсан, одоо манай Нөмрөг уулын л хүн дээ. Чойюмжын Нямжав гэдэг хүн байсан. За тэгээд л тэр хүрээ бол гурван хоногт л дуусаад л , тэгээд л амьтан авч түлээд л тэрүүгээр хийсэн юм байхгүй. Ингээд л дууссан. Ийм л түүхтэй хүрээ. Энд болвол

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

манай энэ Рашаан гүний хошуунд чинь долоон хутагт төрсөн. Долоон хутагтын зургаа нь бол одоо энэ Ойгон нуурын энэ хавьд төрсөн. За тэрнээс хамгийн их нэр алдартай , улсын хэмжээгээр нэр алдар нь түгсэн тийм хутагтууд бол Жалханз хутагт Дамдинбазар, энэ Дилав хутагт Жамсранжав ийм хүмүүсүүд. 1921 оны ардын хувьсгал болж байхад одоо энд маш их үүрэг гүйцэтгэсэн хоёр хутагт бол энэ хоёр. Манай эндээс гарч Ховдод нутагтаж байсан Арь гэгээн Дамдинчогдон. Тэр бол бас тэр хувьсгалд орж их чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэр хутагтууд бол ийм л түүхтэй . Бас ер нь тухайн үедээ ч , энэ шинэ төрийн үедээ ч идэвхтэй зүтгэсэн. Тэгээд тэр Жалханз хутагт, Дилав хутагт хоёрын зургийг нь одоо хотод гар урлалаар хийлгэж тэгээд одоо хийддээ аравнайлж залсан.Ийм л учиртай юм.

Билэг-Өрнөх: За баярлалаа.

Цэдэндорж: Тэгээд 8 хүнээр хурал эхэлсэн. 1992 онд эхэлсэн. За тэгээд яахав дээ, насны эрэмбээр цувж үхээд одоо би ганцаараа хоцорч байна. Би одоо 86 настай. Одоо бол хийдэд бол таван ламын данстай. Нэг нь бол одоо хотод шашны дээд сургуульд сурч байна. Тэр бол онц сурдаг.Гадаадын улсуудын бас хөрөнгийн дэмжлэгтэй сурдаг юм, тэр Германы дэмжлэгтэй сурч байгаа Магсаржавын Бямбадорж гэж тийм лам шавь байгаа. Тэгээд л одоо тэрнийгээ ирж энийг хүлээж авах байх гээд л ингээд байж байна даа. Нэг нь хотод ээжийгээ дагаад шилжээд явчихсан. Одоо энд амралтаараа ирчихээд л байж байна.